



MONGOLIAN INSURERS ASSOCIATION  
МОНГОЛЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО

# ХҮРТЭЭМЖТЭЙ ДААТГАЛ БА МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ОРОЛЦОО

Ж.БАТ-ОРШИХ  
Монголын Даатгагчдын Холбооны  
Ерөнхийлөгч

Улаанбаатар хот  
2014.11.07

## АГУУЛГА

- Даатгалын салбарын өнөөгийн байдал
- Хүртээмжтэй даатгал ба иргэдийн оролцоо
- Хүртээмжтэй даатгалд мэргэжлийн байгууллагуудын оролцоог сайжруулах асуудал



# НЭГ. ДААТГАЛЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ




## ДААТГАЛЫН САЛБАРЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИД

Үзүүлэлт	2008	2009	2010	2011	2012	2013
Даатгагч	16	18	17	17	18	17
Даатгалын компанийн салбар	120	129	138	188	213	240
Даатгалын төлөөлөгч	1167	1676	2061	2057	2357	2950
Даатгалын зуучлагч	4	5	9	8	17	20
Даатгалын хохирол үнэлэгч	-	2	6	9	9	11
Актуарч	9	10	12	13	18	15
Нийт	1196	1711	2105	2104	2419	3253




# ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН НИЙТ ХӨРӨНГӨ



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй 17 компанийн нийт хөрөнгийн хэмжээ 126.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх 2012 оны мөн үетэй харьцуулахад 18.8 тэрбум төгрөгөөр буюу 1.2 дахин өссөн байна. Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ сүүлийн 5 жилд 3.1 дахин нэмэгдсэн дүнтэй байна. Эдгээрээс гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын хөрөнгийн хэмжээ 20.3 хувийг эзэлж байна.

Эх сурвалж: СЗХ, 2013 оны даатгалын зах зээлийн нэгдсэн танилцуулга  
МОНГОЛЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО

# ДААТГАЛЫН НӨӨЦИЙН САН




Даатгалын нөөц сангийн үлдэгдлийг сүүлийн 5 жилийн байдлаар зэрэгцүүлж үзэхэд тогтвортой өсч ирсэн. 2009 оны 4 дүгээр улирлын байдлаар даатгалын нөөц сангийн хэмжээ 24.7 тэрбум төгрөг байсан бол 2013 оны эцэст 57.3 тэрбум төгрөгт хүрч 5 жилийн өмнөх мөн үеийнхээс 2.3 дахин нэмэгдсэн байна.

Эх сурвалж: СЗХ, 2013 оны даатгалын зах зээлийн нэгдсэн танилцуулга  
МОНГОЛЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО

# ДААТГАЛЫН НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО

/тэрбум.төг/




2003 оноос хойш 2013 он хүртэл нийт орлогын өсөлт 87.5 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт харагдаж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 1.2 дахин нэмэгдсэн нь 2012 оноос “Жолоочийн даатгалын тухай хууль” батлагдаж хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой бөгөөд албан журмаар даатгуулах даатгуулагчдын тоо нэмэгдэж, даатгалын хураамжийн орлогыг сүүлийн жилийн дундажаас огцом өссөн байна.

Эх сурвалж: СЗХ, 2013 оны даатгалын зах зээлийн нэгдсэн танилцуулга  
МОНГОЛЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО

# ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

/тэрбум.төг/




2013 онд даатгагчийн нөхөн төлбөр 26.5 тэрбум төгрөгт хүрч сүүлийн 10 жилийн өмнөх үеэс 25.2 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй харагдаж байна. Энэ үзүүлэлтээс харахад нөхөн төлбөр тогтмол өссөн үзүүлэлт ажиглагдаж байна. 2013 онд даатгалын хохирлын харьцаа даатгалын салбарын дүнгээр **42.0** хувь болж 5 жилийн өмнөх үеийнхээс 8.5 пунктээр, өмнөх оны мөн үеэс 7.1 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

Эх сурвалж: СЗХ, 2013 оны даатгалын зах зээлийн нэгдсэн танилцуулга






## ДААТГАЛЫН НЯГТШИЛ (1 ХҮНД НОГДОХ ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО)



Нийт хураамжийн орлого 93.9 тэрбум төгрөг болсон бөгөөд нэг хүнд ногдох хураамжийн орлого 32.4 мянган төгрөгт хүрчээ. Энэ үзүүлэлт 2003 оноос хойш даруй 15.2 дахин, өмнөх оны мөн үеийнхээс 3.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Эх сурвалж: СЗХ, 2013 оны даатгалын зах зээлийн нэгдсэн танилцуулга  
МОНГОЛЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО

# ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭВТРЭЛТ (ДНБ-Д ЭЗЛЭХ ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО)



Эх сурвалж: СЗХ, 2013 оны даатгалын зах зээлийн нэгдсэн танилцуулга



## ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ДААТГАЛ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО



# ХҮРТЭЭМЖТЭЙ ДААТГАЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

## Зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлын талаар

Бага, дунд орлоготой иргэд санхүүгийн, тэр дундаа даатгалын үйлчилгээг хүлээн авах боломж хомс

Даатгалын эрэлт – даатгалд хамрагдаагүй зах зээлийн хэмжээ болон тэдгээрийн хүсч буй даатгалын үйлчилгээг тодорхойлох,

Бага дунд орлоготой иргэдэд хандсан бүтээгдэхүүн үйлчилгээ буй эсэх

Борлуулалтын суваг

Даатгагчдын соёл

## Хүртээмжтэй даатгалын үйлчилгээний гол шинж чанарууд?

Хөдөлмөрийн насны бүх иргэд хүлээн авах боломж бүхий даатгалын бүтээгдэхүүн нь дараах шинж чанаруудыг агуулна. Үүнд:

Бага хураамжийн хэмжээ

Тодорхой, хязгаарлагдмал даатгалын хамгаалалт

Даатгалын гэрээ богино, ойлгомжтой, энгийн байх

Нөхөн төлбөр олгохоос татгалзах үндэслэл бага

Шуурхай, уян хатан нөхөн төлбөр олгох боломжтой.

Хүртээмжтэй даатгалын үйлчилгээний нэг хэлбэр нь бичил даатгал бөгөөд бичил даатгалын Чанарын болон тоон хэмжигдэхүүнээр тодорхойлох 2 үндсэн зарчим байна. тухайлбал Филиппин улс бичил даатгалыг тодорхойлохдоо “нэг өдөрт ногдох хураамж нь өдөр тутмын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хувиас ихгүй байх ба даатгалын үнэлгээ нь өдөр тутмын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 500 дахин үржүүлснээс ихгүй байх



# ДААТГАЛЫН ХАМРАЛТ

	Даатгуулагчийн тоо		Нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо	
	Хувь хүн	Байгууллага	Хувь хүн	Байгууллага
2010 он	676,676	14,989	9,788	9,130
2011 он	1,116,997	13,215	10,783	10,649
2012 он	818,451	60,097	14,636	12,950
2013 он	1,004,260	82,577	13,707	42,093

Даатгалын салбарын хөгжлийн сүүлийн жилүүдийн динамик үзүүлэлтүүдийг харьцуулж үзэхэд даатгалын зах зээл эрчимтэй хөгжиж, даатгалын байгууллагуудын тоо, даатгагчдын нийт хөрөнгө, хураамжийн орлого, нэг хүнд ногдох даатгалын хураамжийн хэмжээ өсч байгаа нь даатгалын хамралт нэмэгдэж, аж ахуйн нэгж, иргэдийн даатгалд хандах хандлага нэмэгдсэнтэй холбоотой юм. Гэхдээ энэ үзүүлэлтүүд бусад орныхтой харьцуулахад бага



## ДААТГАЛЫН ХАМРАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС:

---

1. 2003 оноос Банк-даатгалын хамтын ажиллагаа
2. 2006 онд Малын индексжүүлсэн даатгал
3. 2008 онд Бичил даатгалын төсөл
4. 2008 оноос хойш гадаадын шууд хөрөнгө оруулалт, уул уурхай олборлолт
5. 2012 оноос Албан журмын жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтээс хамаарч даатгалын хүртээмж, хамралтыг нэмэгдүүлэхэд нөлөөлж ирсэн.



## ХҮРТЭЭМЖТЭЙ ДААТГАЛ БА МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ОРОЛЦОО

---

- Нийлүүлэгч тал буюу даатгагч талын бэрхшээлүүд
    - Бизнесийн туршлага бага
    - Мэдээллийн дутмаг байдал
    - Хураамжийн хэмжээ бага, техник ажил ихтэй
    - Зорилтот бүлэгт даатгалын үйлчилгээ хүргэхэд зардал өндөр
    - Борлуулалтын суваг
  - Худалдан авагч буюу даатгуулагч талын бэрхшээлүүд
    - Бага орлого
    - Тогтвортой бус орлого
    - Санхүүгийн мэдлэгийн хомс байдал
    - Даатгалд хамрагдах заншил тогтоогүй
    - Даатгалын салбарт итгэх итгэл сул
  - Хүртээмжтэй даатгалын үйлчилгээг нэвтрүүлэх хөшүүрэг
    - Шинэ зах зээл
    - Ашигт ажиллагаа
- Нийгмийн өмнө хүлээх хариуцлага



## ХҮРТЭЭМЖТЭЙ ДААТГАЛ БА МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ОРОЛЦОО

---

- Тусгай зөвшөөрөл бүхий даатгагч байх  
Бичил даатгалыг тодорхойлж, тусгай зөвшөөрөл олгодог байх тогтолцоог бүрдүүлэх
- Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах  
Эрх тэгш хандах-Бага асуудал, том асуудалд адил тэнцүү хандах
- Компанийн засаглалыг сайжруулах
- Олон нийтийн мэдлэгийг сайжруулах арга хэмжээг авах
- Маргаан шийдвэрлэх тогтолцоог сайжруулах
  - Омбудсман
  - Эвлэрүүлэн зуучлагч





# ГУРАВ. ХҮРТЭЭМЖТЭЙ ДААТГАЛ БА МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛУУДЫН ОРОЛЦОО



## ХҮРТЭЭМЖТЭЙ ДААТГАЛ БА МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ОРОЛЦОО

---

- Өнөөгийн даатгалын зах зээлийн борлуулалтын суваг
  - Шууд хандалт
  - Даатгалын төлөөлөгч
  - Даатгалын зуучлагч
  - Банк
- Борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх боломж
  - Банк бус санхүүгийн байгууллага
  - Хадгаламж зээлийн хоршоо
  - Жижиг дэлгүүрүүд
  - Супер маркет
  - Инновац болон ИТ шийдэл
  - Шуудангийн сүлжээ
  - Бусад? Цахилгааны байцаагч, кабелийн телевиз, ОСНААК...



## ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО

---

Манай улсад даатгалын хамгийн үнэтэй үйл ажиллагааны суваг буюу даатгалын компани өөрийн салбар сүлжээг хаа сайгүй байгуулан зах зээлд хүрч ажиллаж байна. Хорооноос ч ийм шаардлагыг тавьж, компаниуд ч өөрсдөө энэ үнэтэй сувагруу хошуурч байна.

Манай даатгалын компаниудын андеррайтингийн харьцаа /underwriting ratio/ дэлхийн дундажтай ойролцоо байгаа дэлхийн дундаж дор харуулав. Гэвч бүтцээр нь авч үзвэл зардал нь өндөр, нөхөн төлбөр дэлхийн улс орнуудтай харьцуулахад маш бага хувь хэмжээтэй байна.



## ХОХИРОЛ ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО

---

Сүүлийн жилүүдэд хураамжийн орлого нэмэгдэх хэрээр нөхөн төлбөрийн хэмжээ, тохиолдлын онцлог байдал олон янз болж, нэг тохиолдлын хохирлын үнэлгээ эрс нэмэгдэж байна. Үүнээс улбаалан Хохирол үнэлгээчдийн үүрэг роль, үнэнч шудрага, ёс зүйтэй, хөндлөнгийн болон мэргэжлийн байх шаардлага улам бүр өсөн нэмэгдэж байгаа билээ.

Олон улсын туршлагаар Хохирол үнэлгээчин /Loss adjuster/ нь даатгалын тохиолдлын газар дээрх үзлэгийг хараат бус байдлаар хийж хохирол болсон шалтгаан, үнэлгээ, даатгалын гэрээний дагуу олгогдох эсэх тайланг хараат бусаар бэлтгэж баталгаажуулдаг, даатгалын зүйлийн үнэлгээнээс гадна инженер, хими, физик зэрэг олон талын өргөн мэдлэгтэй байдаг. Зохицуулах байгууллагаас ойрын хугацаанд энэ тал дээр гадна дотны туршлага судалж шинэчлэл хийх шаардлагатай байна.



## ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО

---

- Даатгалын салбарын бодлогыг бусад салбаруудын /санхүүгийн салбар/ бодлого тогтолцоотой уялдуулах
- Төр, хувийн хэвшлийн хоорондын уялдаа холбоог сайжруулах
- Үндэсний давхар даатгалын тогтолцоог бий болгох
- Заавал даатгалын тогтолцоог өргөжүүлэх замаар иргэдийн даатгалын боловсролыг дээшлүүлэх
- Зах зээлийн багтаамж, эрэлтээс хэт давсан компаниудын тоог хязгаарлаж чадавхитай цөөн компаниуд үйл ажиллагаа явуулах



## ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО

---

2004 онд батлагдсан Даатгалын тухай хууль нь даатгалын салбарын өнөөдрийн харилцааг зохицуулахад үүргээ бүрэн гүйцэд гүйцэтгэж чадахгүй болжээ.

- Гадны хөрөнгө оруулалттай томоохон компаниуд дотоодын компаниар дамжуулалгүйгээр шууд гадагшаа даатгуулж байгааг зогсоох.
- Нөөц сан дүрмийн сангаас хувьцаанд хөрөнгө оруулалт хийх боломжийг бий болгох
- Нөхөн төлбөрийн маргааныг шийдвэрлэх субъектийг тодорхой болгох
- Банкны даатгалын зуучлалын үйл ажиллагааны зохицуулалтыг тодорхой болгох.



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

